



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/108 -

Улаанбаатар хот

### Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/645 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдахаар шийдвэрлэгдсэн нийт 323,122,410.00 (гурван зуун хорин гурван сая нэг зуун хорин хоёр мянга дөрвөн зуун арав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий үлдэх өртөггүй 9 тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (Э.Товуудорж)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлтийг хийж, тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарыг хураан авч, авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (Э.Товуудорж)-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т тус тус даалгасугай.

ДАРГА



В.ОЮУМАА



אשר/

ג' תשרי ה'תשנ"ב

אשר/... (אשר/...)

אשר/... (אשר/...)

אשר/... (אשר/...)

אשר/... (אשר/...)

אשר/... (אשר/...)

אשר/... (אשר/...)



אשר/... (אשר/...)

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын  
2025 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн  
А/108/21 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах тээврийн хэрэгслийн жагсаалт

№	Автомашины марк	Улсын дугаар	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Hyundai Accent	54-06 УНЗ	45,022,190.0	45,022,190.0	-
2	Hyundai Accent	17-06 УНП	45,022,190.0	45,022,190.0	-
3	Hyundai Accent	62-16 УНЗ	43,108,030.0	43,108,030.0	-
4	УАЗ 220695	77-92 УНЛ	31,630,000.0	31,630,000.0	-
5	Hyundai Accent	68-26 УНЗ	45,740,000.0	45,740,000.0	-
6	Hyundai Accent	48-36 УНЗ	45,740,000.0	45,740,000.0	-
7	УАЗ 220695	19-46 УНУ	31,630,000.0	31,630,000.0	-
8	Hyundai Starex	30-20 УНУ	3,600,000.0	3,600,000.0	-
9	УАЗ 220695	07-20 УБР	31,630,000.0	31,630,000.0	-
Нийт дүн			323,122,410.0	323,122,410.0	-